

#ЭмэгтэйчүүдБидБолУс 2022 оны кампанит ажлын нийгмийн сүлжээн дээрх мэдээллийн багц

Жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлүүд болон үүнд хөрөнгө оруулах шаардлагатайг онцлох нь

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөс (3-р сарын 8) Дэлхийн Усны Өдөр (3-р сарын 22) хүртэл дэлхийн өнцөг булан бүрийн охид, эмэгтэйчүүд, транс, интерсекс болон хүйсийн аль нэг туйлд харъяалагддаггүй хүмүүсийн санаачилсан жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлүүдийг онцлох зорилгоор бидэнтэй нэгдээрэй. [Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтнүүдийн хорооны \(IPCC\) 6-дугаар үнэлгээний тайлангийн хоёр дахь хэсэгт](#) шударга ёс, эрх тэгш байдлыг эн тэргүүнд чухалчлахын хажуугаар шинжлэх ухааны, уугуул иргэдийн болон орон нутгийн мэдлэгийг хослуулснаар уур амьсгалын оновчтой шийдэлд хүрч болохыг онцлон дурджээ. Ийм шийдлүүд бэлэн байдаг ч, эдгээр санаачлага нь санхүүжилтгүй хоцордог бөгөөд үүнийг хэрэгжүүлж буй хүмүүс нь уур амьсгалын өөрчлөлт болон уур амьсгалтай холбоотой усны хомсдолд хамгийн ихээр өртдөг. Гэвч олон улсын санхүүгийн байгууллага, уур амьсгалын сангууд хүмүүсийн газар, хүнсний эрх болон усаар хангагдах хүртээмж, амин чухал экосистемд сөргөөр нөлөөлдөг компани, аж ахуйн нэгжүүдийн ашиг сонирхлыг хамгаалдаг уур амьсгалын хямралд хөрөнгө оруулдаг.

Тийм учраас, бид энэ жил 3-р сарын 8-наас эхлэн “Global Alliance for Green and Gender Action” (GAGGA) буюу Жендэр ба Ногоон Үйл Ажиллагааны Дэлхийн Эвсэл болон манай түнш байгууллагууд нийгмийн сүлжээн дээр **олон улсын санхүүгийн байгууллага болон уур амьсгалын сангуудад томоохон далан, монокультур мод тарих зэрэг уур амьсгалын эдгээр худал хуурмаг шийдлээс татгалзан** бидний ‘жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдэл’ гэж нэрлэх **уур амьсгалын өөрчлөлт, уур амьсгалтай холбоотой ус хомсдох асуудлыг хөндөхийн хажуугаар жендэрийн тэгш бус байдалтай идэвхтэйгээр тэмцдэг олон нийтийн удирдлага бүхий санаачлагуудад нөөц баялагийг хуваарилах шаардлагатайг** харуулах болно. Түүнчлэн GAGGA-гийн дэмжлэг үзүүлдэг олон нийтийн хувьд усны аюулгүй байдал нь хязгаарлагдмал байдгийн хажуугаар тэнд шатах ашигт малтмал олборлоход хөрөнгө оруулсаар байгаа жишээнүүдийг бид онцолно.

Уур амьсгалын шударга, тэгш хамруулсан, тогтвортой шийдлүүд орон нутгийн түвшинд байдаг, харин **эдгээрт хөрөнгө нөөц дайчлах цаг нь болсон**. “Улиг болсон” шийдлүүдийн оронд, хүний төлөө, дэлхий ертөнцийг чухалчилдаг, эмэгтэйчүүдээр удирдуулсан, хувьсган өөрчлөх чадвартай уур амьсгалын шийдлүүдийг дэмжихүйц уур амьсгалын санхүүжилтыг шаардах энэхүү кампанит ажилд нэгдээрэй.

Бидний шаардлагыг өргөн хүрээгээр таниулахын тулд мессэжийг нийгмийн сүлжээнд цааш нь постлож, шейрлэж, түгээнэ үү. Аяны ажлын мэдэгдлийг бүхлээр нь [ЭНДЭЭС](#) харна уу.

Постлох цагийн хуваарь, нийгмийн сүлжээн дэх мессэжүүд болон график/зургийн холбоосуудыг дор дурдсан. Мөн Гүүгл Слайд дээр график/зургууд байгаа ба эдгээрийг өөрсдийн агуулга, нөхцөлд тохируулан өөрчлөхдөө мессэжийг өөрсдийн эх хэлнээ буулгаж, байгууллагынхаа логог оруулна. Дэлхий нийтээр өрнүүлж буй тус аянаар 5 кейсийг л онцолж байгаа ч, та бүхэн тус аяны нэгэн хэсэг болж өөр өөрсдийн улс орны холбогдох түүхээ хуваалцахыг бид уриалж байна.

Тус кампанит ажлыг Фейсбүүк, Инстаграм болон Твиттер дээр [#WeWomenAreWater](#) ба [#LasMujeresSomosAgua](#) ([#ЭмэгтэйчүүдБидБолУс](#)) хаштагийг ашиглаж та бүхэн аянд нэгдэцгээнэ үү. Хэрвээ асуулт байвал GAGGA-гийн харилцаа холбооны стратегич Рани Робелус руу GAGGAcommunication@fcmujeres.org хаягаар цахим шуудан илгээнэ үү.

Хаштагууд

Пост оруулахдаа 1-2 #хаштаг оруулах ба ингэхдээ үргэлж [#WeWomenAreWater](#), [#LasMujeresSomosAgua](#)-ийн аль нэгийг ашиглана. Үүнээс гадна та бүхний ашиглаж болох зарим хаштагийг энд дурдав:

[#WaterIsaHumanRight/#УсБолХүнийЭрх](#) [#WomenClimateJustice/#ЭмэгтэйчүүдУурАмьсгалынШударгаЁс](#)
[#WomenGenderClimate/#ЭмэгтэйчүүдЖендэрУурАмьсгал](#) [#ClimateFinance/#УурАмьсгалынСанхүүжилт](#)
[#GenderJust/#ЖендэрийнХувьдШударга](#) [#ClimateAction/#УурАмьсгалынҮйлАжиллагаа](#) [#ClimateJustice/#УурАмьсгалынШударгаЁс](#)
[#Climate/#УурАмьсгал](#) [#FalseSolutions/#ХуурамчШийдлүүд](#) [#GenderJustice/#ЖендэрийнШударгаЁс](#)
[#FeministClimateJustice/#ФеминистУурАмьсгалынШударгаЁс](#) [#JustTransition/#ШударгаШилжилт](#) [#JustSolutions/#ШударгаШийдлүүд](#)

3-р сарын 8: [#IWD2022](#) буюу [#ОУЭӨ2022](#), [#InternationalWomensDay](#) буюу [#ОлонУлсынЭмэгтэйчүүдийнӨдөр](#), [#WomensDay](#) буюу [#ЭмэгтэйчүүдийнӨдөр](#) [#IWD](#) буюу [#ОУЭӨ](#)

3-р сарын 14, Далангийн эсрэг болон Голуудын төлөөх үйл ажиллагааны Олон улсын өдөр: [#RiversUniteUs](#) буюу [#ГолуудБиднийгНэгтгэдэг](#), [#DayofActionforRivers](#) буюу [#ГолуудынТөлөөхҮйлАжиллагааныӨдөр](#), [#Rivers4Biodiversity](#) буюу [#БиологийнОлонЯнзБайдлынТөлөөхГолууд](#)

3-р сарын 21: [#InternationalDayOfForests](#) буюу [#ОлонУлсынОйнӨдөр](#)

3-р сарын 22: #WorldWaterDay буюу #ДэлхийнУсныӨдөр

Твиттер дээр биднийг [@GAGGA_Alliance](#) гэж тагласнаар бид таны постыг дахин жиргэнэ. Түүнчлэн уур амьсгалын чиглэлээрх санхүүжүүлэгчид, түншлэлүүд болон хамтран ажиллагсдыг давхар таглаж болно.

График/зургууд

Өөрийн Твиттер хуудасны толгой зурагт зориулж аяны имиж зургийг [эндээс](#) татаж аваарай.

Өөрийн Фейсбүүкийн ковер зурагт зориулж аяны имиж зургийг [эндээс](#) татаж аваарай.

[Өөрсдийн агуулга, нөхцөл байдалтай уялдуулж өөрчлөн ашиглаж болох аяны ажлын бүх мэдээллийн график/зургуудыг энд дарж авна.](#) Ингэхдээ эмэгтэйчүүд, ус болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мессэжүүдийг эх хэл дээрээ буулгаж, байгууллагынхаа логог оруулна. Та бүхэн доорх постлох цагийн хуваарьт дурдсан мессэжүүд болон энэхүү баримт бичгийн эцэст дурдсан нэмэлт мессэжүүдийг аяны ажилдаа ашиглаж болно.

Постлох цагийн хуваарь

Түүхийн линк, холбоосууд	Санал болгох мессэжүүд	График	Огноо
Аяны ажлын мэдэгдэл	#ОУЭӨ2022 дэлхийн охид, эмэгтэйчүүд, транс, интерсекс ба аль нэг хүйст хамаардаггүй хүмүүсийн #уурамьсгалыншийдлийг онцлохоор 3-р сарын 8-22-нд аянд нэгдээрэй. ОУ-ын санхүүгийн б/-ллага, УА-ын сангууд компаниудын ашиг сонирхлыг хамгаалсан санаачлагад хөрөнгө оруулсаар ирсэн (1/2) Цаг нь болсон:	Графикийг эндээс харна уу	3-р сарын 8 Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр

	<p> Уур амьсгалын хуурамч шийдлээс #Татгалз  #ЖендэрийнХувьдШударга уур амьсгалын шийдэлд хөрөнгө оруул</p> <p>Хүн, дэлхий ертөнцийг чухалчилсан эмэгтэйчүүдээр удирдуулсан, хувьсган өөрчлөх чадвартай УА-ын шийдлүүдийг дэмжихүйц УА-ын санхүүжилтыг шаардсан бидний шаардлагыг шейрлээрэй. #WeWomenAreWater</p> <p>https://gaggaalliance.org/gagga-2022-%d0%be%d0%bd%d1%8b-%d1%8d%d0%bc%d1%8d%d0%b3%d1%82%d1%8d%d0%b9%d1%87%d2%af%d2%af%d0%b4%d0%b1%d0%b8%d0%b4%d0%b1%d0%be%d0%bb%d1%83%d1%81-%d0%b0%d1%8f%d0%bd%d1%8b%d0%b3-%d0%bd%d1%8d%d1%8d/</p> <p>(График дээрх таг: @GAGGA_Alliance @theGCF @the_IDB @ADB_HQ @EIB)</p>		
<p>Эмэгтэйчүүд Нигерийн Дельта мужид мангрын ой модыг нөхөн сэргээж байна</p>	<p><i>Нигерийн Дельта муж дэлхийн 3 дахь том мангрын ой мод бөгөөд уламжлалт халуун бүсийн ойтой харьцуулахад нүүрстөрөгчийг 4 дахин илүү хураадаг ч, газрын тос асгарч, нипа дал мод тарьснаас мангр мод ирэх 50 жилд устахаар байна. Эмэгтэйчүүд үүний эсрэг тэмцэж байна </i></p> <p>https://gaggaalliance.org/%d1%8d%d0%bc%d1%8d%d0%b3%d1%82%d1%8d%d0%b9%d1%87%d2%af%d2%af%d0%b4-%d0%bd%d0%b8%d0%b3%d0%b5%d1%80%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b4%d0%b5%d0%bb%d1%8c%d1%82%d0%b0-%d0%bc%d1%83%d0%b6%d0%b8%d0%b4-%d0%bc%d0%b0/</p> <p>(Твиттер дээрх таг: @Shell @HYPREPNigeria @GAGGA_Alliance @lokiakawomen Фейсбүүк дээрх таг: @Lokiaka Centre)</p>	<p>Графикийг эндээс харна уу</p>	<p>3-р сарын 10</p>

<p>Магар эмэгтэйчүүд уур амьсгалын үр нөлөөг багасгахаар уугуул иргэдийн мэдлэгийг ашиглаж байна</p>	<p>Балба улсад томоохон усан цахилгаан станцыг яарч барих нь уугуул иргэдийн эрхийг зөрчиж, эрсдэл их байна. Уугуул иргэд, олон нийтийг газар нутгаас нь зайлуулах нь уур амьсгалын хямралыг бууруулж, дасан зохицоход ашиглах мэдлэгээ өвлүүлэх чадамжид нь сөргөөр нөлөөлнө. #WeWomenAreWater #DayofActionforRivers #RiversUniteUs</p> <p>https://gaggaalliance.org/%d0%bc%d0%b0%d0%b3%d0%b0%d1%80-%d1%8d%d0%bc%d1%8d%d0%b3%d1%82%d1%8d%d0%b9%d1%87%d2%af%d2%af%d0%b4-%d1%83%d1%83%d1%80-%d0%b0%d0%bc%d1%8c%d1%81%d0%b3%d0%b0%d0%bb%d1%8b%d0%bd-%d3%a9%d3%a9%d1%80%d1%87/</p> <p>(Твиттер дээрх таг: @ADB_HQ @EIB @GAGGA_Alliance @Tewaforwomen)</p>	<p>Графикийг эндээс харна уу</p>	<p>3-р сарын 14: Далангийн эсрэг болон Голуудын төлөөх үйл ажиллагааны Олон улсын өдөр</p>
<p>Думагат эмэгтэйчүүд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулж, дасан зохицоход мод бэлтгэлийн бус ойн бүтээгдэхүүнийг ашиглаж байна</p>	<p>Думагат эмэгтэйчүүд тэдний амжиргаа, хүнс болон эмийн эх үүсвэр болсон мод бэлтгэлийн бус ойн бүтээгдэхүүнийг (зөгийн бал, жимс) боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Далан барих нь дээрх бүтээгдэхүүн болон орон нутгийнхны амьдралын хэв маягийг устгах эрсдэлд хүргэж байна. #WeWomenAreWater</p> <p>https://gaggaalliance.org/%d0%b4%d1%83%d0%bc%d0%b0%d0%b3%d0%b0%d1%82-%d1%8d%d0%bc%d1%8d%d0%b3%d1%82%d1%8d%d0%b9%d1%87%d2%af%d2%af%d0%b4-%d1%83%d1%83%d1%80-%d0%b0%d0%bc%d1%8c%d1%81%d0%b3%d0%b0%d0%bb%d1%8b%d0%bd-%d3%a9%d3%a9/</p> <p>(Твиттер дээрх таг: @GAGGA_Alliance @ntfper_ph @ntfp_ep @mwssro @NCIPipra @DENROfficial @dargovph Фейсбүүк дээрх таг: @NotByTimberAlone @MWSS Regulatory Office @National Commission on Indigenous Peoples @Department of Environment and Natural Resources (DENR) @StopKaliwaDam Инстаграм дээрх график/зургийн таг: @NotByTimberAlone)</p>	<p>Графикийг эндээс харна уу</p>	<p>3-р сарын 17</p>

<p>Ком эмэгтэйчүүд Парагвайн Чакод уугуул ой модыг авч үлдэхээр тэмцэж байна</p>	<p>Монокультур мод тарихад оруулах @УАНС-гийн хөрөнгө оруулалт нь Парагвайн Чако дахь Ком эмэгтэйчүүд шиг уугуул эмэгтэйчүүд, олон нийтийн эрхийг бэхжүүлснээр ой модыг аварч, байгалийн усны эргэлтийг сэргээхэд ашиглаж болох байсан санхүүжилтыг булааж байна. #WeWomenAreWater</p> <p>[Түүхийн линк]</p> <p>(Твиттер дээрх таг: @fmujeresdelsur @GAGGA_Alliance Фейсбүүк дээрх таг: @fmujeresdelsur Инстаграм дээрх график/зургийн таг: @fmujeresdelsur)</p>	<p>Графикийг эндээс харна уу</p>	<p>3-р сарын 21: Олон улсын ойн өдөр</p>
<p>Маяа омгийн Чорти эмэгтэйчүүд газар нутгийн эрх болон усаа буцааж өөрийн болголоо</p>	<p>17 жилийн турш Маяа омгийн Чорти хүмүүс тэд болон тэдний өвөг дээдэс үе дамжин суурьшсан өөрсдийн газар нутгийн эзэмшлийн төлөө тэмцсэн. Био түлш тариалснаар усны хүртээмжгүй болсон тэд олон нийтээрээ өөр бусад шийдлүүдийг олжээ. #WeWomenAreWater #WorldWaterDay</p> <p>[Түүхийн линк]</p> <p>(Твиттер дээрх таг: @TierraVivagt @GAGGA_Alliance @the_IDB Фейсбүүк дээрх таг: @TierraVivaGuatemala)</p>	<p>Графикийг эндээс харна уу</p>	<p>3-р сарын 22: Дэлхийн усны өдөр</p>

Нийгмийн сүлжээн дээр түгээх мессэжийн хувилбарууд

Дээрх график/зургуудыг өөрсдийн агуулга, нөхцөл байдалд тохируулж өөрчилж болох учраас эмэгтэйчүүд, ус, уур амьсгалын өөрчлөлт болон уур амьсгалын санхүүжилттэй холбоотой мессэжүүдийг нэмж оруулна.

- Өнөөгийн нөхцөл байдал: уур амьсгалын санхүүжилт улиг болсон шийдлүүдийг дэмжиж байна. Бидний хүсч буй бодит байдал: уур амьсгалын санхүүжилт эмэгтэйчүүд болон галын зурваст тэмцэж буй олон нийтийн гардан хэрэгжүүлдэг хувьсган өөрчлөх чадвартай шийдлүүдийг дэмжих ёстой.

- Дэлхий даяар санхүүжилтын зөвхөн 0.01% нь уур амьсгал болон эмэгтэйчүүдийн эрхийг хөндсөн төслүүдийг дэмждэг учраас, жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдэлд одооноос эхлэн илүү их хэмжээгээр хөрөнгө оруулах шаардлагатай.
- “Улиг болсон” шийдлүүдэд хөрөнгө оруулахаа зогсоо. Хүний төлөө, дэлхий ертөнцийг чухалчилдаг эмэгтэйчүүдээр удирдуулсан уур амьсгалын бодит шийдлүүдэд хөрөнгө оруул.
- Уур амьсгалын шударга, тэгш хамруулсан, тогтвортой шийдлүүд орон нутгийн түвшинд байдаг, харин эдгээрт хөрөнгө нөөц дайчлах цаг нь болсон.
- Охид, эмэгтэйчүүдийн удирдан хэрэгжүүлдэг хувьсган өөрчлөх чадвартай уур амьсгалын болон усны шийдлүүдэд хөрөнгө оруулах цаг нь болсон.
- Усыг бохирдуулдаг шатах ашигт малтмал, уур амьсгалын худал хуурмаг шийдлүүд болон хөдөө аж ахуйн аж үйлдвэрт хөрөнгө оруулахаа зогсоо. Жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлүүдэд хөрөнгө оруул.
- Жендэрийн болон усны шударга ёсонд төвлөрдөг уур амьсгалын шийдэлд хөрөнгө оруул.
- Хувьсган өөрчлөх чадвартай уур амьсгалын үйл ажиллагаанд охид, эмэгтэйчүүдийн шаардлага, манлайллыг төвлөрүүл.
- Уур амьсгалын худал хуурмаг шийдлүүдээс татгалзаж, жендэрийн хувьд шударга шийдлүүдэд хөрөнгө оруул.
- Эмэгтэйчүүд, уугуул иргэд болон орон нутгийн олон нийтийн үзэл бодол, зөвшөөрөл, хяналтыг тусгасан жендэрийн хувьд шударга уур амьсгалын шийдлүүдийг яг одоо хэрэгжүүл.
- #УурАмьсгалынӨөрчлөлт болон [#COVID19](#) нь БҮХ хүнийг усны аюулгүй байдлаар хангах яаралтай хэрэгцээ шаардлагыг харуулж байна.